



# АУДИТЫН ТАЙЛАН

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ийн  
2014 оны 12 дугаар сарын 31-  
ний өдрөөр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот 2015 он



2015 он 01 сар 29 өдөр

№ 01/07

Улаанбаатар хот

**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД  
БОЛОН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД****Хараат бус аудиторын дүгнэлт**

Бид “Гермес центр” ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга (цаашид “санхүүгийн тайлан” гэнэ)-д аудит хийлээ.

**Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага**

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (цаашид СТОУС гэх) дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг, хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөрдөх ба нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх зэрэг нь энэхүү хариуцлагад хамаарна.

**Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Хийсэн аудитын ажилдаа үндэслэн санхүүгийн тайланд хараат бус байдлаар дүгнэлт гаргах нь аудитор бидний үүрэг хариуцлага билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Аудитын Олон Улсын Стандартын дагуу бид санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи хүчин төгөлдөр, хангалттай нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрддөг.

Санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаархи аудитын нотолгоог олж авахын тулд зохих горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд хамаардаг.

### Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)

Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх эрсдлийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс компанийн санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн компанийн удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн материаллаг тооцооллын үндэслэл болон санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид найдаж байна.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, аудитласан санхүүгийн тайлан нь “Гермес центр” ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.




*Аудиторын дүгнэлт нь хавсралт тайлангуудын хамт хүчин төгөлдөр байна*

**"ГЕРМЕС ЦЕНТР" ХК**  
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

*(Төгсгөөр)*

	<i>Тод</i>	<u>2013/12/31</u>	<u>2014/12/31</u>
<b>ХӨРӨНГӨ</b>			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	4	1,012,837,361.15	1,108,191,166.05
Дансны авлага	5	1,382,870.00	3,702,333.33
Бусад авлага	6	279,728,205.80	205,040,950.00
Бараа материал	7	42,775,426.56	7,193,956.56
Урьдчилж төлсөн зардал		-	1,000,000.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>1,336,723,863.51</b>	<b>1,325,128,405.94</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	8	4,846,199,631.99	4,802,622,172.89
Биет бус хөрөнгө	9	2,305,945,029.44	2,294,625,753.08
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>7,152,144,661.43</b>	<b>7,097,247,925.97</b>
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>8,488,868,524.94</b>	<b>8,422,376,331.91</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	10	24,873,759.00	19,017,500.00
Татвар, шимтгэлийн өглөг	11	8,742,145.38	19,686,351.71
Бусад өглөг	12	128,568,598.42	175,743,633.55
Урьдчилж төлөгдсөн орлого	13	-	1,841,904.97
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>162,184,502.80</b>	<b>216,289,390.23</b>
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр		-	-
<b>ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>162,184,502.80</b>	<b>216,289,390.23</b>
<b>ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	14	7,854,300,138.63	7,854,300,138.63
Хуримтлагдсан ашиг	15	472,383,883.51	351,786,803.05
<b>ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>8,326,684,022.14</b>	<b>8,206,086,941.68</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>8,488,868,524.94</b>	<b>8,422,376,331.91</b>

*Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно*



**"ГЕРМЕС ЦЕНТР" ХК**  
**АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

		<i>(Тогроогоор)</i>	
	<i>Тод</i>	<u>2013/12/31</u>	<u>2014/12/31</u>
Цэвэр борлуулалтын орлого	16	1,229,671,338.49	1,367,026,698.85
Борлуулалтын өртөг	55	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>1,229,671,338.49</b>	<b>1,367,026,698.85</b>
Түрээсийн орлого			
Хүүний орлого	18	50,008,253.19	67,177,315.21
Ноогдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого			
Борлуулалт, маркетингийн зардал			
Ерөнхий ба удирдлагын зардал	17	(771,767,851.96)	(718,202,056.71)
Санхүүгийн зардал			
Бусад зардал			
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	18	8,969.07	5,612.95
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	18	-	190,215,840.98
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулалтаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		507,920,708.79	906,223,411.28
Орлогын албан татварын зардал	19	(50,791,173.97)	(89,782,013.92)
Татварын дараах ашиг (алдагдал)		<u>457,129,534.82</u>	<u>816,441,397.36</u>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		<u>457,129,534.82</u>	<u>816,441,397.36</u>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн		<u>457,129,534.82</u>	<u>816,441,397.36</u>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		<u>5.82</u>	<u>10.39</u>

*Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно*



"ГЕРМЕС ЦЕНТР" ХК  
 АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

(Товчоор)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халааны хувьцаа	Ижэж тоглогсон кацигал	Хоронгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Галаад валютын хөрвүүлэлтийн нооц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2012 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,854,300,138.63							
Нягтлан болох бүртгэлийн боловчын өөрчлөлтийн нооцоо, алдааны заруулга							459,051,727.15	8,313,351,865.78
Заруулсан үлдэгдэл								
Тайланг үечийн нэмэр ашиг (авлагдан)								
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт							459,051,727.15	8,313,351,865.78
Зарласан ногдол ашиг							457,129,534.82	457,129,534.82
Дахин үнэлгээний нэмэлтийн хэрэгжсэн дүн							(443,797,378.46)	(443,797,378.46)
2013 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,854,300,138.63							
Нягтлан болох бүртгэлийн боловчын өөрчлөлтийн нооцоо, алдааны заруулга							472,383,883.51	8,326,684,022.14
Заруулсан үлдэгдэл								
Тайланг үечийн нэмэр ашиг (авлагдан)								
Бусад дэлгэрэнгүй орлого							816,441,397.36	816,441,397.36
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг							(937,038,477.82)	(937,038,477.82)
Дахин үнэлгээний нэмэлтийн хэрэгжсэн дүн								
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	7,854,300,138.63						351,786,803.05	8,206,086,941.68

Тайлан нь бүртгэлийн санхүүг хэсэг болно




**"ГЕРМЕС ЦЕНТР" ХК**  
**АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

(Төгрөгөөр)

	2013-12-31	2014-12-31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	1,831,920,621.94	3,176,239,910.53
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,375,350,126.52	1,478,225,889.06
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	456,570,495.42	1,698,014,021.47
Мөнгөн зарлагын дүн (-)	(1,173,695,256.01)	(1,469,532,083.81)
Ажилчдад төлсөн	197,531,689.84	204,921,753.80
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,673,159.86	56,675,390.80
Бараа материал худалдан авахад төлсөн	53,137,449.03	252,099,033.61
Ашиглалтын зардалд төлсөн	135,628,111.89	196,601,376.14
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,026,384.95	7,821,832.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	258,785,170.84	277,709,547.20
Даатгалын төлбөрт төлсөн	7,706,400.00	5,957,734.00
Бусад мөнгөн зарлага	455,206,889.60	467,765,416.26
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>658,225,365.93</b>	<b>1,706,687,826.72</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	50,004,260.99	67,177,315.21
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	50,004,260.99	67,177,315.21
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	(66,650,000.00)	(835,885,171.48)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,650,000.00	835,885,171.48
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,645,739.01)</b>	<b>(768,707,856.27)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	(360,147,896.58)	(842,631,778.50)
Зээл, өрийн үнэ цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	360,147,896.58	842,631,778.50
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(360,147,896.58)</b>	<b>(842,631,778.50)</b>
Валютын ханшийн зөрүү	8,969.07	5,612.95
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>281,440,699.41</b>	<b>95,353,804.90</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>731,396,661.74</b>	<b>1,012,837,361.15</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,012,837,361.15</b>	<b>1,108,191,166.05</b>
		(0.00)

Тайлан нь дүгнэлтийн саллигүй хэсэг болно



**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА  
2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР  
ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

**1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА**

“Гермес Центр” ХХК-ийг Хувь нийлүүлэгчдийн хурлын 2003 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 01 тоот тогтоолоор үүсгэн байгуулж, компанийн дүрмийг баталсан.

“Гермес Центр” ХХК нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль болон бусад холбогдох, хууль тогтоомжийн дагуу хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн эх үүсвэр, сонирхлын үндсэн дээр супермаркет, гадаад худалдаа, түрээсийн үйлчилгээ эрхлэх зорилгоор, хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан, Монгол Улсын хуулийн этгээд юм.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 99 тоот тогтоолоор компанийн энгийн хувьцааны тоог баталж, нийт энгийн хувьцааны 30 хувийг олон нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн ба тогтоолын дагуу зарласан хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр худалдсанаар нээлттэй Хувьцаат компани болсон.

2008 оны 5 дугаар сард барилгын материал, гэр ахуйн тавилгын худалдааны төвийг барьж ашиглалтанд оруулан иргэд, аж ахуйн нэгжид түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлсэнээр, борлуулалтын орлогын ихэнхи хувийг түрээсийн орлогоор бүрдүүлж байна.

Компани 2009 оноос Орхон аймаг Баян-Өндөр суманд өөрийн салбараа нээн ажиллуулж байна.

**2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ**

**Нягтлан бодох бүртгэлийн үндэс**

Компани санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон Сангийн яамнаас баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар”, “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж, гаргах аргачлал”-ын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэдэг.

**Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют**

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн.



#### **Үнэлгээ**

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэдэг.

#### **Нягтлан бодох бүртгэлийн суурь**

Компани нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

#### **Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл**

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

### **3. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО**

#### **Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хэрэгслүүд**

Мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах дансаас бүрддэг. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг.

#### **Авлага**

Авлагыг тухайн үеийн нэхэмжлэх дүнгээр тайлагнадаг. Авлагын хувьд насжилт гаргаж, цуглуулагдах магадлалыг үнэлж тооцдоггүй. Өөрөөр хэлбэл цэвэр боломжит үнэ цэнийг тооцдоггүй, найдваргүй авлагын нөөцийн сан байгуулдаггүй.

#### **Бараа материал**

Бараа материалыг тэдгээрийн өнөөгийн байршилд авчрахад гарсан зардлуудын нийт хэмжээгээр буюу өртгөөр нь бүртгэдэг. Бараа материалын бүрэлдэхүүнд бичиг хэргийн материал, хөдөлмөр хамгааллын хувцас, цэвэрлэгээний материал, сэлбэг хэрэгсэл, бараа зэрэг хамаарна. Бараа материалыг тайлант хугацаанд анх худалдан авсан үеийн түүхэн өртгөөр зарлага болгож, бараа материалын цаг үеийн системийг ашиглан бүртгэсэн.

#### **Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо**

Худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд бүртгэдэг. Мөнгөөр төлөгдсөн бөгөөд дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэдэг. Урьдчилж гарсан зардлыг хамрах тайлант үеийн холбогдох зардлын дансанд хаадаг. Урьдчилж төлсөн зардал, тооцоог төлсөн мөнгөний дүнгээр илэрхийлдэг.

### Үндсэн хөрөнгө ба элэгдэл

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүнийг олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтад орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг, үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	Ашиглагдах хугацаа /жилээр/
Барилга, байгууламж	40
Тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компьютер, дагалдах хэрэгслэл	3-5
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж НББОУС-16-н дагуу дансны үнэ, балансын өдрөөрхи бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийдэг.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байвал зөрүүг өмчид хүлээн зөвшөөрдөг. Харин дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ буурч байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### Биет бус хөрөнгө

Ажил үйлчилгээний нийлүүлэлтэд бодон удирдлагын зориулалтаар ашиглахаар эзэмшиж байгаа биет шинж чанаргүй, харьцангуй удаан хугацаагаар ашиглагдах хөрөнгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

Компани биет бус хөрөнгөнд хамааруулан газар эзэмших эрх, зохион байгуулалтын зардал, программ хангамжийг бүртгэсэн.

Биет бус хөрөнгийг түүнд тооцсон хорогдуулгыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар тооцдог ба биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох хугацаа дараах байдалтай байна.

### Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Биет бус хөрөнгийн төрөл	Ашиглагдах хугацаа /жилээр/
Газар эзэмших эрх	60
Зохион байгуулалтын зардал	5
Санхүүгийн программ хангамж	3

### Дансны өглөг

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардлыг хуримтлуулсанаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг. Өр төлбөрөөс тооцох аливаа хөнгөлөлт, хасагдуулга байхгүй. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн үлдэгдлийг тайлант хугацааны эцэст Монголбанкны хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлэн тайлагнадаг.

### Бусад өглөг

Түрээсийн барьцаа болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуйн нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### Татвар, шимтгэлийн өглөг

Монгол Улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон бусад татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

### Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашиг (алдагдал)-с бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг, (алдагдал) нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр үр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

### **Борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрөх**

Байр түрээслүүлсэнээс олох түрээсийн орлогыг түрээслэгчийн байр ашигласан сард нь ногдуулан нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн орлогыг түрээсийн гэрээнд заасан дүнгээр, түүхэн өртгөөр бүртгэдэг.

Түрээсийн нийт орлогоос борлуулалтын хөнгөлөлт, буцаалтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд илэрхийлдэг.

### **Борлуулалтын өртгийг хүлээн зөвшөөрөх**

Борлуулалтын орлоготой уялдуулж, нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар борлуулалтын өртгийг хүлээн зөвшөөрдөг.

### **Үйл ажиллагааны зардал**

Компанийн удирдлагын үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ноогдох дүнгээр нь нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бүртгэдэг.

### **Үйл ажиллагааны бус орлого, зардал**

Үйл ажиллагааны бус орлого, зардлыг ажил гүйлгээ бодитой хэрэгжсэн үед хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгадаг.

### **Гадаад валютын гүйлгээ**

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийж, ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг ханшийн тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг.

### **Татвар**

#### Орлогын татвар

Монгол Улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ноогдуулах жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ноогдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ноогдуулж төлдөг.

#### Нэмэгдсэн өртгийн татвар

Борлуулалтад 10 хувиар тооцож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг. Нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн татварыг борлуулалтаас тооцсон уг татварын өглөгөөс суутган тооцдог.

Хувь хүний орлогын албан татвар

Монгол Улсын "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу ажиллагчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 10-н хувиар тооцож, хувь хүний орлогын албан татвар ноогдуулж, суутгадаг.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд тусгагдсан үнийн дүнгээс 1.0 хувиар тооцон үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлдөг.

Тээврийн хэрэгсэлийн албан татвар

Компанийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулинд заасан хувь хэмжээгээр албан татвар ногдуулан төлдөг.

Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол Улсын Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу ажиллагчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод даатгуулагч 10.0 хувиар, ажил олгогч 11.0 хувиар тооцож нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Энэ нь Засгийн газрын нийгмийн даатгалын төлөвлөгөө бөгөөд компани ажиллагчиддаа зориулсан тусгай нийгмийн даатгалын төлөвлөгөө, сангүй болно.

#### 4. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүнийг доор харуулав.

Ангилал	2013/12/31	2014/12/31
а. Касс		
Касс төгрөгийн /тов/	26,754,786.22	9,344,108.82
Дүн	26,754,786.22	9,344,108.82
б. Харилцах		
ХХБ төгрөгийн харилцах данс 499096623 /тов/	165,317,846.93	98,752,222.48
Төрийн банк төгрөгийн харилцах 3405003364 /Эрдэнэт/	724,074.17	48,567.97
ХХБ валютын харилцах данс 499096634 /тов/ <small>ᠰᠢᠨᠢᠨᠠᠨᠢ</small>	40,653.83	46,266.78
ХХБ төгрөгийн хадгаламж 13000005621	820,000,000.00	1,000,000,000.00
Дүн	986,082,574.93	1,098,847,057.23
<b>Мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>1,012,837,361.15</b>	<b>1,108,191,166.05</b>

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.09 дахин буюу 95.4 сая төгрөгөөр өссөн. Мөнгөн хөрөнгийг зөв байршуулж ажилласнаар мөнгөн хадгаламж өмнөх оны мөн үеийнхээс 180.0 сая төгрөгөөр өссөн бөгөөд тайлант онд 67.2 сая төгрөгийн орлого олж ажилласан.

#### 5. ДАНСНЫ АВЛАГА

Дансны авлагын дансдын ангилал, үлдэгдэл дараах байдалтай байна.

Ангилал	2013/12/31	2014/12/31
Түрээслэгчээс авах авлага	430,000.00	3,702,333.33
Бараа борлуулалт авлага	952,870.00	-
<b>Дансны авлагын дүн</b>	<b>1,382,870.00</b>	<b>3,702,333.33</b>

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дансны авлага 2,319,463.33 төгрөгөөр буюу 2.68 дахин өссөн байна.

#### 6. БУСАД АВЛАГА

Бусад авлагын дансдын ангилал, үлдэгдэл дараах байдалтай байна.

Ангилал	2013/12/31	2014/12/31
Холбоотой талаас авах авлага	180,000,000.00	160,000,000.00
Ажилчдаас авах авлага	5,500,000.00	-
Байгууллагаас авах авлага	94,228,205.80	45,040,950.00
<b>Дансны авлагын дүн</b>	<b>279,728,205.80</b>	<b>205,040,950.00</b>

2013 оны байдлаар холбоотой тал болох 1 хүнээс авах авлага 180,0 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 20,0 сая төгрөгийг барагдуулж, 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хувьцаа эзэмшигч 1 хүнээс авах 160,0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь, мөн бусад байгууллагаас авах авлагыг 52.2 хувиар бууруулсан нь нийтдээ өмнөх оны авлагыг 26.7 хувиар бууруулсан байна.

## 7. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын данс дараах үлдэгдэл, дансаас бүрдэж байна.

<u>Ангилал</u>	<u>2013/12/31</u>	<u>2014/12/31</u>
Дуусаагүй барилга	36,978,000.00	-
Барилгын материал	666,800.00	660,200.00
Хөдөлмөр хамгаалал	1,956,875.50	3,391,875.50
Бичиг хэргийн материал	251,130.56	146,010.56
Багаж, сэлбэг хэрэгсэл	102,830.00	602,830.00
Хангамжийн материал	2,819,790.50	2,393,040.50
<u>Дансны авлагын дүн</u>	<u>42,775,426.56</u>	<u>7,193,956.56</u>

### 8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн анхны ба үлдэгдэл өртөг, тайланг үеийн ба хуримтлагдсан элэгдлийг гол ангиллын дагуу харуулав.

Үзүүлэлт	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Компьютер, дагалдах хэрэгсэл	Нийт дүн
<b>Өртөг</b>						
2013-12-31	5,622,384,150.92	36,881,000.00	123,130,329.74	65,158,079.00	9,784,778.00	5,857,338,337.66
Нэмэгдсэн	833,631,741.05	-	399,000.00	1,854,430.43	-	835,885,171.48
Хасагдсан	806,639,310.00	-	3,980,500.00	-	4,727,788.00	815,347,598.00
<b>2014-12-31</b>	<b>5,649,376,581.97</b>	<b>36,881,000.00</b>	<b>119,548,829.74</b>	<b>67,012,509.43</b>	<b>5,056,990.00</b>	<b>5,877,875,911.14</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>						
2013-12-31	867,052,783.33	32,360,716.96	66,707,238.04	36,835,645.76	8,182,321.58	1,011,138,705.67
Нэмэгдсэн	122,130,353.91	3,688,099.92	24,779,655.27	6,927,903.56	763,133.00	158,289,145.66
Хасагдсан	88,055,953.32	-	1,714,697.74	-	4,403,462.02	94,174,113.08
<b>2014-12-31</b>	<b>901,127,183.92</b>	<b>36,048,816.88</b>	<b>89,772,195.57</b>	<b>43,763,549.32</b>	<b>4,541,992.56</b>	<b>1,075,253,738.25</b>
<b>Үлдэгдэл өртөг</b>						
2013-12-31	4,755,331,367.59	4,520,283.04	56,423,091.70	28,322,433.24	1,602,456.42	4,846,199,631.99
<b>2014-12-31</b>	<b>4,748,249,398.05</b>	<b>832,183.12</b>	<b>29,776,634.17</b>	<b>23,248,960.11</b>	<b>514,997.44</b>	<b>4,802,622,172.89</b>



## 9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгийн данс дараах үлдэгдэлтэй байна.

Үзүүлэлт	Программ хангамж	Газар эзэмших эрх	Зохнон байгуулалтын зардал	Нийт дүн
<b>Өртөг</b>				
Нэмэгдсэн Хасагдсан	3,090,000.00	2,451,960,000.00	182,600,928.16	2,637,650,928.16
2013/12/31				
Хуримтлагдсан элэгдэл	1,308,000.00	-	-	1,308,000.00
2014/12/31	1,782,000.00	2,451,960,000.00	182,600,928.16	2,636,342,928.16
Байгуулсан хорогдуулга Хасагдсан	2,379,389.04	163,464,000.00	165,862,509.68	331,705,898.72
2013/12/31	516,666.72	-	10,651,720.80	11,168,387.52
2014/12/31	1,157,111.16	-	-	1,157,111.16
Үлдэгдэл өртөг	1,738,944.60	163,464,000.00	176,514,230.48	341,717,175.08
2013/12/31	710,610.96	2,288,496,000.00	16,738,418.48	2,305,945,029.44
2014/12/31	43,055.40	2,288,496,000.00	6,086,697.68	2,294,625,753.08

## 10. ДАНСНЫ ӨГЛӨГ

Ангилал	2013/12/31	2014/12/31
Түрээслэгчид өгөх өглөг	30,259.00	-
Байгууллагад өгөх өглөг	24,843,500.00	19,017,500.00
<b>Дансны өглөг</b>	<b>24,873,759.00</b>	<b>19,017,500.00</b>

## 11. ТАТВАР, ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

Ангилал	2013/12/31	2014/12/31
ААНОАТ-ын өглөг	8,428,521.00	19,382,545.69
НӨАТ-ын өглөг	313,624.38	303,806.02
<b>Татвар шимтгэлийн өглөг</b>	<b>8,742,145.38</b>	<b>19,686,351.71</b>

## 12. БУСАД ӨГЛӨГ

Бусад өглөгийн данс нь дараах үлдэгдэл, дансдаас бүрдэж байна.

Ангилал	2013/12/31	2014/12/31
Түрээсийн барьцааны өглөг	91,424,910.00	162,941,650.00
Хувь хүмүүст өгөх өглөг	69,091.20	16,234.46
Цалингаас суутгасан сан	1,808,492.00	1,780,692.00
Байгууллагад өгөх өглөг	1,698,260.08	1,698,260.08
Сурталчилгааны сан	9,853,347.00	9,197,347.00
Цалин урамшууллын сан	23,714,498.14	109,450.01
<b>Дансны авлагын дүн</b>	<b>128,568,598.42</b>	<b>175,743,633.55</b>

### 13. УРЬДЧИЛЖ ТӨЛӨГДСӨН ОРЛОГО

Ангилал	2013/12/31	2014/12/31
Урьдчилж олсон орлого /түрээс/	-	1,841,904.97
Урьдчилж төлөгдсөн орлого	-	1,841,904.97

### 14. ХУВЬЦААТ КАПИТАЛ

2008 оны 01 дүгээр сарын 17-ний бүртгэлээр компанийн дүрмийн сан 5,498,010.1 мянган төгрөг болж үүсгэн байгуулагчдын тоо 3 байсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 99 тоот тогтоолоор компанийн энгийн хувьцааны тоог 78,543,001 ширхэгээр баталж, нийт энгийн хувьцааны 30 хувь болох 23,562,900 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгийн нэрлэсэн үнээр олон нийтэд худалдахыг зөвшөөрсөн.

Тогтоолын дагуу энгийн хувьцааны 30 хувь болох 23,562,900 ширхэг хувьцааг 100 төгрөгийн нэрлэсэн үнээр нь Монголын Хөрөнгийн Биржээр худалдсан нь хувьцаат капиталыг 2,356,290.00 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Үзүүлэлт	2013/12/31	2014/12/31
01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдэл	7,854,300,138.63	7,854,300,138.63
Нэмж гаргасан хувьцаа	-	-
Халаасалсан хувьцаа	-	-
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	7,854,300,138.63	7,854,300,138.63

Компанийн хувьцаат капиталын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 78,543,001 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

### 15. ХУРИМТЛАГДСАН АШИГ

Үзүүлэлт	2013/12/31	2014/12/31
01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдэл	459,051,727.15	472,383,883.51
Тайлант үеийн цэвэр ашиг	457,129,534.82	816,441,397.36
ТУЗ-ын 2013 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 2 тоот тушаалаар хуваарилсан ногдол ашиг	(443,797,378.46)	-
ТУЗ-ын 2014 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 5 тоот тушаалаар хуваарилсан ногдол ашиг	-	(457,129,534.82)
ТУЗ-ын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 13 тоот тушаалаар хуваарилсан ногдол ашиг	-	(479,908,943.01)
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	472,383,883.51	351,786,803.04

## 16. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Борлуулалтын орлого нь дараах бүрэлдэхүүнтэй байв.

Орлогын зүйлс	2013/12/31	2014/12/31
Түрээсийн орлого	1,217,590,389.08	1,349,631,650.30
Түрээсийн алдангийн орлого	2,376,384.07	3,555,464.59
Цахилгаан борлуулсны орлого	9,704,565.34	13,839,583.96
<b>Нийт борлуулалтын орлогын дүн</b>	<b>1,229,671,338.49</b>	<b>1,367,026,698.85</b>

Түрээсийн орлого борлуулалтын орлогын 98.7 хувийг эзэлж байна

### Орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	2013.12.31	2014.12.31	Өөрчлөлт	
			Тоо	Пункт
Түрээсийн орлого	1,217,590,389.08	1,349,631,650.30	132,041,261.22	110.84%
Түрээсийн алдангийн орлого	2,376,384.07	3,555,464.59	1,179,080.52	149.62%
Цахилгаан борлуулсны орлого	9,704,565.34	13,839,583.96	4,135,018.62	142.61%
<b>Нийт цэвэр орлого</b>	<b>1,229,671,338.49</b>	<b>1,367,026,698.85</b>	<b>137,355,360.36</b>	<b>111.17%</b>
Өртөг	-	-	-	0.00%
<b>НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>1,229,671,338.49</b>	<b>1,367,026,698.85</b>	<b>137,355,360.36</b>	<b>111.17%</b>
Банкны хүүний орлого	50,008,253.19	67,177,315.21	17,169,062.02	134.33%
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	190,215,840.98	190,215,840.98	100.00%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>50,008,253.19</b>	<b>257,393,156.19</b>	<b>207,384,903.00</b>	<b>514.70%</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	771,767,851.96	718,202,056.71	(53,565,795.25)	93.06%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>771,767,851.96</b>	<b>718,202,056.71</b>	<b>(53,565,795.25)</b>	<b>93.06%</b>
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>507,911,739.72</b>	<b>906,217,798.33</b>	<b>398,306,058.61</b>	<b>178.42%</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8,969.07	5,612.95	(3,356.12)	62.58%
<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>8,969.07</b>	<b>5,612.95</b>	<b>(3,356.12)</b>	<b>62.58%</b>
<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>507,920,708.79</b>	<b>906,223,411.28</b>	<b>398,302,702.49</b>	<b>178.42%</b>
Орлогын албан татварын зардал	50,791,173.97	89,782,013.92	38,990,839.95	176.77%
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>457,129,534.82</b>	<b>816,441,397.36</b>	<b>359,311,862.54</b>	<b>178.60%</b>

Тайлант хугацаанд борлуулалтын орлогыг 11.17 хувиар, үндсэн үйл ажиллагааны ашгийг 78.42 хувиар нэмэгдүүлж, ерөнхий ба удирдлагын зардлыг 6.94 хувиар бууруулж ажилласан байна. Эрдэнэт хотод байршилтай өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулснаар 190.2 мянган төгрөгийн орлого олж ажилласан нь тайлант үеийн цэвэр ашгийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

### 17. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Ерөнхий ба удирдлагын зардлын бүрэлдэхүүнийг дараах байдлаар харуулав.

Зардлын зүйлс	2013/12/31	2014/12/31
Ажилчдын цалингийн зардал	214,731,389.00	234,655,557.00
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	25,192,053.00	29,039,897.53
Засвар үйлчилгээний зардал	42,810,636.60	17,800,216.07
Ашиглалтын зардал	108,541,875.45	104,436,442.72
Албан томилолтын зардал	769,300.00	424,200.00
Тээврийн зардал	3,540,800.00	2,097,590.00
Элэгдлийн зардал	192,596,451.55	169,032,092.08
Зар сурталчилгааны зардал	157,960.00	-
Шуудан холбооны зардал	2,841,004.28	4,706,704.79
Шатахууны зардал	4,634,912.88	5,315,151.11
Шагнал урамшууллын зардал	-	34,387,137.67
Тэтгэмж тусламжийн зардал	-	1,300,000.00
Хангамж материалын зардал	55,609,522.40	42,908,650.85
Бусад татварын зардал	52,997,284.93	55,179,268.42
Банкны шимтгэлийн зардал	94,276.12	48,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	3,950,000.00	6,199,922.56
Даатгалын зардал	7,706,400.00	5,957,734.00
Зохион байгуулалтын зардал	1,687,510.00	1,710,150.00
Сургалтын зардал	1,255,000.00	-
ХЧТА-ийн тэтгэмж зардал	297,954.00	-
Үнэт цаасны хураамж	1,200,000.00	1,909,200.00
Дохиолол хамгаалал зардал	4,909,091.64	818,181.91
Найдваргүй авлагын зардал	1,019,626.63	-
Шагнал урамшууллын зардал	32,377,653.48	-
Тэтгэмж тусламжийн зардал	8,616,960.00	-
Нөхөн сэргээлтийн зардал	32,030.00	-
Бусад зардал	4,198,160.00	275,160.00
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>771,767,851.96</b>	<b>718,202,056.71</b>

### 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО, ЗАРДАЛ

Үйл ажиллагааны бус орлого, зардлын бүрэлдэхүүнийг дараах байдлаар харуулав.

Орлогын зүйлс	2013/12/31	2014/12/31
Хүүний орлого	50,008,253.19	67,177,315.21
Валютын ханшын зөрүүгийн ашиг	23,457.63	25,774.49
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	190,215,840.98
<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>	<b>50,031,710.82</b>	<b>257,418,930.68</b>
Зардлын зүйлс	2013/12/31	2014/12/31
Валютын ханшын зөрүүгийн алдагдал	(14,488.56)	(20,161.54)
<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>	<b>(14,488.56)</b>	<b>(20,161.54)</b>
<b>Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)</b>	<b>50,017,222.26</b>	<b>257,398,769.14</b>

### 19. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Үзүүлэлт	2013/12/31	2014/12/31
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	507,920,708.79	906,223,411.28
Ноогдуулсан татвар 10%	50,792,070.88	90,622,341.13
Нийтлэг хувь хэмжээгээр ноогдуулсан татвар	45,791,245.56	64,883,025.51
Тусгайлан хувь хэмжээгээр ноогдуулсан татвар	5,000,825.32	24,899,549.70
Ханшийн зорүүгийн бодит бус ашигт ногдсон татвар	(896.91)	(561.30)
Нийт орлогын албан татварын зардал	50,791,173.97	89,782,013.92

### 20. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Бидэнд танилцуулсанаар 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр томоохон зарга маргаан, нэхэмжлэл үгүй байна. Өөрөөр хэлбэл, компанийн тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөр байхгүй.